Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, АДХ Гүйцэтгэх захиргааны сонин.

16 дахь жилдээ № 23 (1358) | 1964 оны 3 дугаар сарын 19 | ПҮРЭВ

## Аймгийн ХЗЭ—ийн XI бага хурал

Өнөөдөр аймгийн ХЗЭ-ийн XI бага хурал, аймгийн соёлын ордонд нээгдлээ. Бага хурал, аймгийн ХЗЭ-ийн байгууллагуудаас урьдах бага хурлаас хойш хийж ирсэн ажлын тайлан илтгэлийг аймгийн ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Д.Товуу тавилаа.

Бага хуралд таслах эрхтэй 66 төлөөлөгч, сонгогдсоны дотор БНМАУ-ын хөдөлмөрийн баатар МХЗЭ-ийн гишүүн Цэрэн—очир, Баянцогтын сангийн аж ахуйн трактор, комбайнч тэргүүний тариаланч алтан медальт МХЗЭ—ийн гишүүн Сүрэнхорлоо, Жаргалантын 11 жилийн сургуулийн сурагч онц сурлагатан Мандаа, Батсүмбэрийн САА-н ХЗЭ—ийн Хорооны дарга Гүндсамбуу нарын ажил хөдөлмөрөөрөө шалгарсан тэргүүний хүмүүс оролцож байна. Аймгийн ХЗЭ-ийн бага хурлыг тус аймгийн ХЗЭ-ийн гишүүд залуучууд хөдөлмөр сурлагын бахдам амжилтаар угтав.

Зуд эсэргүүцэх, төлийн бэлтгэл хангах, залуучуудын олон арван цуваа гарч 80 хашаа шинээр барьж засварлан төлийн пүнз 48-ыг барьж 1643 тонн өвс, 169 тонн хужир, татан бэлтгэжээ. Төл хүлээн авах бэлтгэл хангахад зориулан ухуулах бригад 18 ажиллан 20 мянга гаруй хүнд урлаг, киногоор үйлчилж, ухуулга яриа хийжээ.

Аймгийн төвийн артель, хүнсний үйлдвэрийн залуучуудын дунд бага хурлын нэрэмжит өндөр бүтээлийн 30 хоногийн ажил зохиогдож ажилчин залуучууд төлөвлөгөөгөө 106,5—106,7 хувиар биелүүлэв.

Бага хурлын нэрэмжит цанын өртөөчилсөн тойрон аялал олонх сумдыг хамран 141 залуу аялалд оролцож, 20 гаруй суурь, бригадын хот хороог тохижуулсан байна. МХЗЭ-ийн гишүүд, залуучууд бүрэн бус мэдээгээр шувуу 1500 гаруй, туулай 163-ыг агнаж, 805 тонн төмөр цуглуулжээ.

Аймгийн ХЗЭ-ийн байгууллагын дотоод зохион байгуулалт, үзэл суртал, хүмүүжлийн ажлыг бүх талаар сайжруулж, МХЗЭ-ийн гишүүд, залуучуудыг аймгийн аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд дайчлан зохион байгуулах зорилт тус бага хурлын өмнө зогсож байна.

Юуны урьд МХЗЭ—ийн үндсэн байгууллагуудын дотоод ажил, гишүүдтэй ажиллах ажлыг сайжруулж МХЗЭ—ийн гишүүдийн манлайлах ролийг дээшлүүлэхэд онцгой анхаарал тавих ёстой.

Залуучуудын дунд зохиох хүмүүжлийн ажлын агуулга хэлбэрийг баяжуулж, залуу үеийг нийгэм ард түмнийхээ үйл хэргийн төлөө мятаршгүй тэмцдэг, ажилч хичээнгүй, тал бүрийн авъяас мэдлэгтэй шинэ хүмүүсийг бэлтгэхэд МХЗЭ—ийн гэгээрэл хүмүүжлийн ажлыг чиглүүлэх нь чухал байна. МХЗЭ—ийн байгууллагаас зохиох ажлыг залуучууд бүрт хүрэлцхүйцээр өргөн олныг хамарсан туршлагыг уулзалт агуулга, гэгээрлийн хурал зохиох, урлаг спорт хөдөлмөрийн дадлага олгох, курс, семинар зохион байгуулах зэрэг олон хэлбэр ашиглах хэрэгтэй. Ноос, хадлан бэлтгэх, хашаа барих, худаг гаргах, худалдаа бэлтгэлийн ажилд МХЗЭ—ийн байгууллага, гишүүд залуучууд бүрийг тодорхой үүрэгтэй ажиллуулж, амалсан үүргээ хугацаанд нь биелүүлж дүгнэдэг журмыг заншил болговол зохино.

МХЗЭ—ийн хэсэг, үүр, хороо бүрийн ажлыг жигд сайжруулан аймгийн ХЗЭ—ийн XI бага хурлаас гаргах шийдвэрийг дайчин шуурхай биелүүлэхийн төлөө идрийн зориг авъяас билгээ дайчилцгаая.

## Онцын их баяр бахдал

### Нам, засгийнхаа өндөр шагнал хүлээн авч байна

Тус аймгийн иргэн хэн боловч яагаад баярлахгүй байх юм бэ?

Нам, засгийнхаа эрхэм хайр шагналыг түүхэндээ анх удаа хүлээн авч байна шүү дээ!

Бид, 1963 онд ёстой үүлэн борын хурдаар жигүүрлэн урагшлаж, социалист уралдаанаар ташуур хийсэн ард түмэн.

Хараач! Зуун мод хотынхон өнөөдөр ямар их баяр жавхлантай байна вэ? Аймгийн соёл урлагийн төв Соёлын ордон зай завсар алга.

Тэнд төв хөдөөгийн салбар бүрээс ирсэн 156 сайчуул, аймгийн МХЗЭ—ийн XI бага хурлын 120 төлөөлөгч, төв орон нутгийн намын үүр, хороодын орлогчид, зааварлагчид, мөн соёл гэгээрлийн ажилтнууд, албан газрын дарга орлогчид 138 хүн суудлаа дүүрэн эзэлжээ.

—Тэд ажил хийвэл ам тосдоно гэдэг ёстой үнэн үг шүү, сайхан юм. Аймгийн маань нэр төр, олон түмний алдар гавъяа гэлцэн өөр хоорондоо ярилцана.

—Аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Б.Дэжид, МАХН—ын Төв Хороо, БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн эрхэм хүндэт шагнал хүлээн авахаар 52 мянган хүний үнэнч шудрага хөдөлмөрийн оюун санааг өвөрлөж ирсэн 500 гаруй төлөөлөгчдийн баярын цуглааныг зориг бадруулсан үгээр нээв.

МАХН—ын Төв Хорооны гишүүн БНМАУ—ын Ардын Их Хурлын депутат, Намын Төв Хорооны хэлтсийн эрхлэгч нөхөр Б.Чимэд, энд цугларсан төлөөлөгчид болон тэднээр дамжуулан тус аймгийн бүх хөдөлмөрчдөд хандаж дэлгэрэнгүй үг хэлж, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн хүндэт дипломыг аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дарга нөхөр Ц.Жамсранд гардуулав. Нөхөр Ц.Жамсран, хүндэт дипломыг өндөр өргөж тус аймгийн мятрашгүй хөдөлмөрч олон түмнээс 1963 онд олсон хөдөлмөрийн гялалзсан амжилтуудыг дүгнэн яриад, 1964 оны төлөвлөгөөт бүх зорилтыг хугацаанаас нь өмнө давуулан биелүүлэхээ илэрхийлж, нам. засгийнхаа хайр шагнал хүртсэний хариуд баяр хүргэв.

—Өнгөрсөн жил 3 дугаар байр эзэлж шагнагдсан манай тэргүүний аж ахуйн нэг, Батсүмбэрийн сангийн аж ахуйн дарга нөхөр Дарамжав, мал өсгөх төлөвлөгөөг аймагтаа тэргүүн зэрэгт биелүүлсэн Өндөрширээт сум—нэгдлийн намын үүрийн нарийн бичгийн дарга нөхөр Сандуй, Өнжүүл сум—нэгдлийн гишүүн аймгийн 1963 оны аварга адуучин нөхөр Батсүх, худалдаа бэлтгэлийн талаар улсад гуравдугаар байр эзэлж шагнагдсан аймгийн худалдаа бэлтгэлийг удирдах газрын дарга нөхөр Гончиг, ноос бэлтгэлийн ажилд амжилт гаргасны учир, байгууллага нь БНМАУ—ын Засгийн Газрын хүндэт жуух бичгээр шагнагдсан аймгийн хувьсгалт залуучуудын эвлэлийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Товуу, 1963 оны ажилд гаргасан дутагдалдаа тодорхой дүгнэлт хийж, энэ оны эхний саруудад өндөр амжилт олж яваа Баяндэлгэр сум—нэгдлийн намын үүрийн нарийн бичгийн дарга нөхөр Дашзэвэг, аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн захирал нөхөр Содномдаржаа нарын олон хүн тус тусын хамт олноо төлөөлөн нам засагтаа баяр хүргэж 1964 оны төлөвлөгөөт үүргүүдийг хэдийд хэрхэн биелүүлэх тухай нарийн тооцоолон, тодорой тоо баримттай үүрэг авцгаалаа.

—Нам засгийн хайр шагнал, хүлээн авах төв хөдөөгийн хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн баярын энэ цуглаанаас МАХН--ын Төв Хороо, БНМАУ--ын Сайд нарын Зөвлөлд явуулах баярын бичгийг нэгэн дуугаар сайшаан батлав.

—Золбоо хийморь нь бадарч, зориг эрмэлзэл нь ундарсан тус аймгийн бүх хөдөлмөрч ард түмэн, 1964 онд урьдах оныхоо ажилд хуримтлуулсан баялаг туршлагаа газар бүр хүн бүр эзэмшиж, төлөвлөгөөг тоо чанарын үзүүлэлтээр үлэмж давуулан биелүүлэхэд бэлэн байгаагаа нам засагтаа илгээсэн баярын бичигт тодорхойлжээ. Бид хэлж ярихаараа биш хийж бүтээхдээ туршлагажсан ард түмэн юм.

Үүнийг юугаар гэрчлэх вэ? Өтөлж ядарсан мал, өнчин ишиг ч гарздахгүйн төлөө хөр цас ухаж хүйтэн жаварт хайруулахаас буцахгүй зогсож байсан, хаврын аюулт хар шуургатай нойр хоолгүй тэмцэж мал сүргээ аварч байсан, нялх төл бүрийг мал болгохын төлөө хөгшин залуугүй нэг хүн шиг ажиллаж байгаа энэ бүхнээр тодорхойлогдоно.

Тэдний энэ тэмцэлд нам засгийн маань энэ хайр шагнал, асар их хүч зориг нэмж байна.

Үүнийг зүйрлэн хэлбэл; Хатан Туулын мөнгөн долгион шиг хөдөлмөрий нь эрчийг оргилуулж байгаа нь баярын энэ цуглааны бүх ажиллагаа тод томруун харуулж байна.

—Үлэмжийн энэ их баяр хөөр, амнаас амд, айлаас айлд хоромхон зуур түргэн тархаж, бодит амьдрал болох нь гарцаагүй ээ!

## *Баярын хурал болов*

Монгол ардын армийн 43 жилийн ойд зориулсан аймгийн төвийн хөдөлмөрчдийн баярын хурал өчигдөр намын кабинетад болов.

Баярын хурлыг аймгийн АДХ-ын Гүйцэтгэх захиргааны хариуцлагатай нарийн бичгийн дарга нөхөр Дашдорж нээж, аймгийн АДХ-ын Гүйцэтгэх захиргааны цэргийн хэлтсийн орлогч, ахмад Нямжанцан «Ардын армийн 43 жилийн ой» гэсэн илтгэл тавив

Хурлын дараа Зөвлөлт Холбоот улсын уран сайхны «Ижил мөрний тулалдаан» гэдэг кино монгол хэл дээр гарав.

## Баяндэлгэр сумын намын үүр Дашзэвэг, АДХ-ын Гүйцэтгэх захиргаа Төмөрдорж нарт

1964 оны 1 дүгээр улирлын бэлтгэлийн 33 нэр төрлийн төлөвлөгөөг 100—122 хувиар биелүүлсэн явдалд та нар болон танай сумын худалдаа бэлтгэлийн ажилчид, бүтээлч хөдөлмөрчдөд баяр хүргэж, мал өсөлт төл бойжилт бусад төлөвлөгөөт ажилдаа улам их амжилт гаргана гэдэгт бид итгэж байна.

**Аймгийн намын хороо, АДХ-ын Гүйцэтгэх захиргаа.**

## Аймгийн сум хороодын төл бойжилт 1964 оны 3 дугаар сарын 15-ны байдлаар

| № Сумд | хувь |
| --- | --- |
| 1.Алтанбулаг | 98,6 |
| 2.Архуст | 96,9 |
| 3 Батсүмбэр | 98,9 |
| 4 Баян | 99,5 |
| 5 Баянбараат | 96,2 |
| 6.Баяндэлгэр | 95,7 |
| 7.Баянжаргалан | 97,3 |
| 8.Баянзүрх | 97,5 |
| 9 Баянцагаан | 98,1 |
| 10.Баянцогт | 97,6 |
| 11.Борнуур | 93,2 |
| 12 Бүрэн | 98,5 |
| 13.Дэлгэрхаан | 97,5 |
| 14 Жаргалант | 92,8 |
| 15 Заамар | 96,1 |
| 16.Лүн | 90,0 |
| 17.Мөнгөнморьт | 93,5 |
| 18 Өндөрширээт | 98,7 |
| 19.Өнжүүл | 98,2 |
| 20.Сэргэлэн | 99,4 |
| 21.Тариат | 95,7 |
| 22.Угтаал | 95,7 |
| 23.Эрдэнэ | 91,6 |
| 24.Эрдэнэсант | 95,3 |
| 25.Баянчандмань | 100,0 |
| Аймгийн дүн | 95,7 |

## Сумдын 1 дүгээр улирлын бэлтгэлийн төлөвлөгөөний биелэлт 1964 оны 3 дугаар сарын 17—ны байдлаар

| №. | Сумд | Хувь |
| --- | --- | --- |
| 1. | Алтанбулаг | 61,5 |
| 2. | Архуст | 100,0 |
| 3. | Батсүмбэр | 70,5 |
| 4. | Баян | 72,4 |
| 5. | Баянбараат | 65,5 |
| 6. | Баяндэлгэр | 100,0 |
| 7. | Баянжаргалан | 50,0 |
| 8. | Баянцагаан | 88,4 |
| 9. | Баянзүрх | 80,0 |
| 10. | Баянцогт | 91,6 |
| 11. | Баянчандмань | 62,0 |
| 12. | Борнуур | 26,4 |
| 13. | Бүрэн | 37,0 |
| 14. | Дэлгэрхаан | 42,3 |
| 15. | Жаргалант | 37,5 |
| 16. | Заамар | 68,9 |
| 17. | Лүн | 66,6 |
| 18. | Мэнгөнморьт | 91,1 |
| 19. | Өндөрширээт | 22,2 |
| 20. | Өнжүүл | 34,6 |
| 21. | Сэргэлэн | 92,8 |
| 22. | Тариат | 29,6 |
| 23. | Угтаал | 70,0 |
| 24. | Эрдэнэ | 64,7 |
| 25. | Эрдэнэсант | 51,8 |
| 26 | ИХ хайрхан | 52,3 |
| | Аймгийн дүн | 57,1 |

## Сурагчдын идэвх

Мөнгөнморьт сумын бага сургуулийн пионер сурагчид нэгдлийнхээ төлийн бэлтгэлд зориулан нэмнээ 46, элгэвч 91-ийг хийж туслав. Худалдаа бэлтгэлийн ангийн I дүгээр улирлын түүхий эдийн төлөвлөгөө биелүүлэхэд гууль 30 кг, яс 178 кг 500 г бусад эвэр, чих шилбэний яс,хөнгөн цагаан зэргийг тушааж сургуульдаа 44 төгрөг 20 мөнгөний орлого оруулав.

Бүтэд

# Зудын гачаалд зутрахгүй

«Хаврын тэнгэр халгаатай, хавирга нэвт хүйтэнтэй»гэдэг.Сүүлийн үед гэнэт хүйтэрч үе үе цасан шуурга тавих болсон нь малчин залуучуудын бэлтгэл, зориг хатуужил авхаалж самбааг шалгах лут их шалгуур нь болсоор байна

Баян сумын нутгаар 1 дүгээр сарын дунд үеэс эхлэн их хэмжээний цас орж хүйтний эрч 35-40 градус хүрсэн боловч зудын гачаалыг давж мал сүргээ онд оруулах тэмцэлд залуус хушуучилж байна.

Сумын хэмжээгээр төлийн бэлтгэл хангах, зудтай тэмцэх, 7 бригад 63 хүнтэй гарган ажиллаж хашаа 12-ыг барьж, 30-ыг засварлаж ногоон тэжээл 830 тонн, хүчит тэжээл 30 тонныг сууриудад хүргэж, айл нүүлгэх, хот,бууц засаж өгөх,мал тэжээх ажлыг гардан хийж байна.

МХЗЭ—ийн гишүүн Балданцэрэн хариуцсан.суурийнхаа малчдыг сайн зохион байгуулж цасан шуурга,.хүйтэн жаврыг үл хайхран ердийн хөсгөөр өдөр шөнөгүй өвс тээвэрлэж төлийн пүнз барьж хот хороогоо дулаалж бусдаасаа гарамгай амжилт гаргаж байна.

Ингэж Баян сумын залуучууд «зудыг зунаар солъё»гэдэг эрмэлзлэлээр ажиллаж малын үхэл хорогдлыг зогсоогоод байна.

Энэ сумын залуу малчид бэлтгэл сайтай хөдлөж тарган тавтай оторлож«энх сүрэгтэн»«мэнд төлчин»болж «залуучуудын үнэн» сонины 40 жилийн ой, аймгийн ХЗЭ-ийн 11 дүгээр бага хуралдаа ажлын бахдам амжилтаар бэлэг барьж байна.

Д.Цэгмэд

## *Идэрчүүдийн эрчимт хөдөлмөр*

Өнжүүл сумын ХЗЭ—ийн Хорооны гишүүд залуучууд, өнгөрсөн онд хариуцан төллүүлсэн нийгмийн малын төлөө 99,2 хувиар бойжуулж бог малын саравчтай хашаа 10,уурхайн худаг 2-ыг тус тус гаргасан байна.

Сум орны аж ахуй соёлын төлөвлөгөөг биелүүлэх ажилд тус сумын 1, 2 дугаар бригадын эвлэлийн үүр, гишүүд, залуучууд сайн ажиллаж 7 жилийн дунд сургуулийн сурагчид нь сумын зэс,гууль,хөнгөн цагааны төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

МХЗЭ—ийн гишүүн Гончигсүрэн өөрийн санаачлагаар 05 га-д эрдэнэ шиш туршин тариалсан нь амжилттай болж 3 тонн ургац хураан авч сумын 1963 оны тариалангийн аврага болжээ.

МХЗЭ-ийн хорооны гишүүд, залуучууд 1964 оны сумын төлөвлөгөөт хашаа, хороо, худгийн 50 хувь,малын тэжээл бэлтгэлийн 73 хувь,бэлтгэлийн төлөвлөгөөт нохой,шувуу,туулай, зэс, гууль,хөнгөн цагаан,ганга, чихэр өвсний төлөвлөгөөг 100 хувь залуучуудын хүчээр гүйцэтгэх зорилт тавин ажиллаж байна.

З .Пунцагцэрэн

ЭНЭ ЗАЛУУ ЯАЖ ХҮМҮҮЖИВ

# Гурван удаагийн нулмисан дусал

**(Найруулал)**

1

### 1957 оны 9 дүгээр сарын 12.

Шүүх цуглааны ажиллагаа эхлэх хараахан болоогүй байлаа. Хэрэгтний ширээнд сууж хэргээ шийдвэрлүүлэхээр хүлээж буй Сүрэнхорлоогийн сэтгэлд «Яагаад би хэрэгтэн болов оо?» гэдэг бодол тэрхэн агшнаа харван орж хийсэн хэргийнхээ тухай бодов.

«Чоно гол»—ын уул уурхайн сургуулийн өрөмдөгчийн анги төгсөөд «Чулуун хороотын» уурхайд жил гаруй ажиллаж байгаад 2 сарын чөлөөгөөр төрж өссөн өлгий нутаг, үзэсгэлэнт сайхан Завхан аймагт буй эцэг эх, төрөл төрөгсөдтэйгээ уулзахаар 3000 төгрөг өвөрлөөд мордож байснаа бодохоос яагаад би, эцэг эхтэйгээ очиж уулзалгүй ийнхүү «хэргийн эзэн хэнгэргийн дохиур» болов оо? Тиймээ, хүн танихгүй, газар мэдэхгүй, Улаанбаатар хотын тээврийн товчоо хаана байдгийг ч олохгүй явахдаа л архичин, танхай хэсэг нөхөдтэй дарвин нийлж 3000 төгрөгөөр архи ууж, зодоо хийж яваад л өнөөдрөөс эхлээд ийнхүү эрхээ хасуулж, хүний эрхшээлд явах болох нээ дээ.

Гэвч юу гэж шийдвэрлэх бол доо гэж бодно. Шүүх цуглааны ажиллагаа эхлэж,Сүрэнхорлоогийн биеийн байцаалт, яллагч, өмгөөлөгч нар үг хэлж дуусcаны дараа шүүх цуглааны дарга ялын тогтоол уншиж 5 жил хорьж шийтгэх тухай мэдэгдэхэд Сүрэнхорлоогийн нүднээс гэмшлийн анхны нулмис дусалжээ.

### 1962 оны 4 дүгээр сарын 16.

Сүрэнхорлоо, өнгөрсөн хугацаанд шоронгоос оргох, хүмүүжих ажилчидтай зодоо хийх зэргээр аль болохгүй муу бүхнийг хийж байснаас «муу хүн, хүмүүжихгүй хүн» гэж нэрлэгдэх болов Тэрээр улс хувьсгалын 40 жилийн ойн өмнөхөн хэрэг нь цагаатах байсан авч өөрийнхөө төрхгүй, сахилгагүйгээс энэ удаа суллагдсангүй. Сүрэнхорлоогийн сэтгэлд өөр бодол төрлөө. Засан хүмүүжүүлэх газрын даргатай нүүр учран уулзаж; —Би, өдөр бүрийнхээ нормыг 200-гаас доошгүй хувиар биелүүлж, нэг жилийн дотор тэргүүний хүмүүжих ажилчны болзол хангана гэж амлалт авав. Дарга, Сүрэнхорлоогийн хүсэлт ёсоор уг амлалты нь зөвшөөрч чулуун точикт хуваарлан ажиллуулав. Сүрэнхорлоо, ажиллаж буй хугацаандаа өдрийнхөө нормыг 300-гаас дээш хувиар биелүүлж, түүний хүмүүжих тал нь

2

илт мэдэгдэж эхэллээ. Даан удсангүй урьдын Сүрэнхорлоо биш болсон учраас 10 хүн даргалуулан Налайхын их уурхайд хүмүүжих ажилчдын байрыг 30 хоногийн дотор барих үүрэг өгөхөд нь уг ажлаа хугацааны нь өмнө биелүүлжээ. Ингээд л ажлын амжилт олсон Сүрэнхорлоо, алдсан алдаандаа үнэнхүү гэмшиж 1962 оны 4 дүгээр сарын 16-нд суллагдан гарахдаа баярын анхны нулмис дуслуулжээ.

### 1962 оны 6 дугаар сарын 21.

«Төв аймгийн МХЗЭ-ийн хороо» гэсэн хаягийг байн байн харж, орох уу? яахав гэж өөрөө өөртөө асуулт тавьж зогсохдоо миний амьдралын замыг л энэ байгууллага зааж өгнө.

Ямарч байсан орж даргатай нь уулзая гэж эрс шийдэв.

Сүрэнхорлоогийн санаа ёсчлон бүтэж энэ өдөр аймгийн харилцаа холбоонд МХЗЭ-ийн илгээлтээр шилжин очлоо.

Харилцаа холбооны хамт олны дэмжлэг туслалцаатай хариуцуулж өгсөн кумлятор цэнэглэх ажилдаа өдрөөс өдөрт улам бүр дадлагажин,алдсан алдаагаа ажлын амжилтаар л цэвэрлэнэ гэдэг нэгэн бодол өөрийг нь эзэгнэх болов.

Тэгээд аймгийн эмийн сангаас өдөр болгон шахуу л нэг литр нэрмэл ус 80 мөнгөөр худалдаж авдаг байсныг өөрчлөн өөрөө нэрмэл ус гаргах санаа бодож эхэллээ.

Сүрэнхорлоо, уйгагүй оролдож, ихээхэн бодсоны эцэст 1963 оны 2 дугаар сарын 10—даар «ус нэрдэг аппарат» санаачлан хийж ажилдаа хэрэглэснээр 4 мянга гаруй төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.

Сүрэнхорлоо, одоо социалист хөдөлмөрийн төлөө бригадын гишүүн, эхнэр, хүүхэдтэй өнөр сайхан гэр бүлтэй болоод 10 гаруй жил уулзаагүй байсан аав, ээж, ах, эгч нараа авчраад ариун цагаан хөдөлмөрөөр аж төрөн амьдарч байна.

Ингэж л «Алдаж явлаа би, оножж явнаа би» гэсээр яриагаа төгсгөж буй Сүрэнхорлоогийн нүднээ нулмис мэлтэгнэн гүйлгэнэх нь гэнэн залуу насандаа алдаа хийж засан хүмүүжүүлэх газар өнгөрүүлсэн амьдралынхаа тухай сэтгэлд нь бууж гэмшлийн нулмис өөрийн эрхгүй бөмбөрсөн бизээ.

Б.Дорж